**АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН**

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Цемент шохой ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СНАГ-2024/102/НА-СТА-ТӨА**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2024 он | Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер: С.Нацагдорж<br>Утас: 51-261885 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Эрдэнэзул<br>Утас: 51-261740 Цахим хаяг: erdenezulb@audit.gov.mn<br>Нийслэл-Аудит ХХК-ийн захирал: Т.Сугарсүрэн<br>Утас: 70110095 Цахим хаяг: info@niislelaudit.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.22 № 07/771
танай ____________-ны № ____________-т

ЦЕМЕНТ ШОХОЙ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Д.БАТТУВШИН ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Цемент шохой ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Цемент шохой ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 66,487.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу эсвэл нийтээрээ материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Тухайлбал:

- Жилийн эцсийн санхүүгийн тайланд толилуулсан 45,723.6 сая төгрөгийн авлага, 12,867.8 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Санхүүгийн тайланд толилуулсан 16,467.6 сая төгрөгийн татварын өглөг нь татварын тайлангаарх өглөгийн дүнгээс 942.3 сая төгрөгөөр илүү;
- Агуулахад байгаа 1,573.1 сая төгрөгийн бараа материалыг 2 жил дараалан зарцуулаагүй, хэрэгцээ шаардлагыг тодорхойлохгүй худалдан авалт хийснээс 757.5 сая төгрөгийн илүүдэл нөөц үүсгэсэн.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 258 дугаар тогтоолоор Цемент шохой ТӨХК нь Эрдэнэс Монгол ХХК-ийн харьяанд шилжиж, хязгаарлагдмал хариуцлагатай компани болж, Төлөөлөн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэгдсэн байна. Мөн компани үйлдвэрлэлийн гол түүхий эд болох

өндөр илчлэгтэй нүүрсийг бэлтгэн нийлүүлэгчээс шууд худалдан авалт хийж эхэлсэн, эрчим хүчний хэмнэлттэй цагуудад тоног төхөөрөмжүүдийг ажиллуулж, оргил ачааллын үед засвар үйлчилгээг хийж цахилгаан эрчим хүчний хэмнэлт гаргаж ажилласан байна.

Компанийн 2023 оны тодотгосон эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшинд төлөвлөснөөс гүйцэтгэлээр борлуулалт 40 хувиар буурсан байна. Энэ нь зах зээл дээрх ижил үйл ажиллагаатай компаниудын үнэ болон урамшууллын судалгааг хангалттай хийж бүтээгдэхүүний үнийг бодитой тогтоогоогүй, үнэ шинэчлэх шийдвэр гаргалт хэт удаан олон шат дамжлагаар хэлэлцэж баталдаг зэргээс шалтгаалж байна.

**Аудитын гол асуудал**

Цемент шохой ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, компанийн үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант оны нийт орлогыг 91,428.6 сая төгрөгөөр, нийт зардлыг 81,950.3 сая төгрөгөөр, 8,008.7 сая төгрөгийн ашигтай ажиллахаар баталсан ба хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 28,069.9 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 86,268.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 73,262.3 сая төгрөгийн зардал гарган, 11,255.2 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, 8,005.7 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын арга хэмжээнд зарцуулсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Цемент шохой ХХК нь зардлыг бууруулах бүтээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд урьдчилан халаагчтай эргэх зуухаар шохой үйлдвэрлэх төслийн хүрээнд үйлдвэрлэлийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулан эрх бүхий байгууллагаар батлуулжээ. Шохойн үйлдвэр байгуулах төслийг Эрдэнэс Монгол ХХК санхүүжүүлж, бүтээн байгуулалтыг 2024 оноос Эрдэнэс үйлдвэрлэл технологийн парк ХХК гүйцэтгэхээр болсон байна.

Цемент шохой ХХК нь 2023 онд үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлангаар 10 зорилтын хүрээнд 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн 69 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

Z:\Yawsan_Bichig\2024\0315 SNAG-54.Docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*/төгрөгөөр/*

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **ХӨРӨНГӨ** | | |
| **1.1** | **Эргэлтийн хөрөнгө** | | |
| 1.1.1 | Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 6,043,794,423.40 | 242,464,355.22 |
| 1.1.2 | Дансны авлага | 2,317,913,402.89 | 5,398,356,646.06 |
| 1.1.3 | Татвар, НДШ – ийн авлага | 1,021,049,927.31 | 10,414,474.54 |
| 1.1.4 | Бусад авлага | 12,921,614,074.29 | 14,260,562,748.19 |
| 1.1.6 | Бараа материал | 19,239,758,176.89 | 46,090,845,370.70 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 2,479,869,949.47 | 2,706,896,400.51 |
| 1.1.9 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) | 546,192,946.00 | 546,192,946.00 |
| 1.1.11 | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **44,570,192,900.25** | **69,255,732,941.22** |
| **1.2** | **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 230,379,564,442.24 | 227,028,328,601.35 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 5,281,270,068.56 | 8,223,704,778.80 |
| 1.2.4 | Урт хугацаат хөрөнгө оруулалт | 3,110,309,086.42 | 3,167,577,706.42 |
| **1.2.10** | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **238,771,143,597.22** | **238,419,611,086.57** |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **283,341,336,497.47** | **307,675,344,027.79** |
| **2** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| **2.1** | **Өр төлбөр** | | |
| 2.1.1 | **Богино хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 2,897,890,289.78 | 7,821,808,734.36 |
| 2.1.1.2 | Цалингийнөглөг | 72,815,486.00 | 72,815,486.00 |
| 2.1.1.3 | Татварын өр | 12,642,450,074.75 | 16,819,264,078.44 |
| 2.1.1.4 | НДШ - ийн өглөг | - | 1,222,764,163.95 |
| 2.1.1.6 | Хүүний өглөг | 16,372,618,946.34 | 16,372,618,946.34 |
| 2.1.1.7 | Ногдол ашгийн өглөг | - | 5,815,347,850.00 |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | 3,952,807,965.76 | 4,632,613,605.35 |
| 2.1.1.9 | Нөөц/өр төлбөр/ | 16,437,867.72 | 15,437,867.72 |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 249,187,517.26 | 191,211,347.71 |
| **2.1.1.13** | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **36,204,208,147.61** | **52,963,882,079.87** |
| **2.1.2** | **Урт хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | 41,916,835,529.58 | 41,916,835,529.58 |
| 2.1.2.2 | Нөөц /өр төлбөр/ | 2,213,391,285.66 | 2,213,391,285.66 |
| 2.1.2.3 | Хойшлогдсон татварын өр | 3,703,657,012.83 | 3,103,027,378.08 |
| 2.1.2.4 | Бусад урт хугацаат өр төлбөр | 275,738,820,300.00 | 275,738,820,300.00 |
| **2.1.2.6** | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **323,572,704,128.07** | **322,972,074,493.32** |
| 2.2 | **Өр төлбөрийн нийт дүн** | **359,776,912,275.68** | **375,935,956,573.19** |
| **2.3** | **Эздийн өмч** | **11,945,269,000.00** | **11,945,269,000.00** |
| 2.3.1 | Өмч:-төрийн | 11,945,269,000.00 | 11,945,269,000.00 |
| 2.3.2 | хувийн | - | - |
| 2.3.3 | хувьцаат | | |
| 2.3.4 | Халаасны хувьцаа | | |
| 2.3.5 | Нэмж төлөгдсөн капитал | 420,000,000.00 | 420,000,000.00 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 41,284,046,790.95 | 41,284,046,790.95 |

| | | | |
|---|---|---|---|
| 2.3.7 | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | - | - |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 2,861,655,327.46 | 5,428,771,474.66 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | (132,946,546,896.62) | (127,338,699,811.01) |
| 2.3.10 | Тусга зориулалтын нөөцийн сан | - | - |
| **2.3.11** | **Эздийн өмчийн дүн** | **(76,435,575,778.21)** | **(68,260,612,545.40)** |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **283,341,336,497.47** | **307,675,344,027.79** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

*/төгрөгөөр/*

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **Борлуулалтын орлого (цэвэр)** | **95,854,747,844.90** | **85,605,128,141.52** |
| 2 | Борлуулалтын өртөг | 72,497,327,147.76 | 59,551,532,450.57 |
| **3** | **Нийт ашиг( алдагдал)** | **23,357,420,697.14** | **26,053,595,690.95** |
| 4 | Түрээсийн орлого | 18,097,822.91 | 12,188,049.12 |
| 5 | Хүүний орлого | - | 78,288,133.44 |
| 8 | Бусад орлого | 802,456,050.33 | 572,756,819.16 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 2,272,825,405.96 | 3,454,404,948.76 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 3,218,947,957.00 | 9,563,645,617.58 |
| 11 | Санхүүгийн зардал | 1,490,937,241.46 | - |
| 12 | Бусад зардал | 1,972,886,041.97 | 688,872,683.22 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | 10,760,355.52 | (3,825,122.06) |
| **17** | Бусад ашиг ( алдагдал) | | |
| **18** | **Татвар төлөхийн өмнөхашиг( алдагдал)** | **15,233,138,279.51** | **13,006,080,321.05** |
| **19** | Орлогын татварын зардал | 2,986,374,817.20 | 1,750,890,445.51 |
| **20** | **Татварын дараах ашиг (алдагдал)** | **12,246,763,462.31** | **11,255,189,875.54** |
| **21** | **Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)** | | |
| **22** | **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)** | **12,246,763,462.31** | **11,255,189,875.54** |
| **23** | **Бусад дэлгэрэнгүй орлого** | | |
| | Бусадолз (гарз) | | |
| **24** | **Орлогын нийт дүн** | **12,246,763,462.31** | **11,255,189,875.54** |
| **25** | **Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)** | | |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

*/төгрөгөөр/*

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөнгүйлгээ** | | |
| **1.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **99,013,030,529.71** | **84,201,261,636.60** |
| **1.1.1** | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 98,554,028,882.35 | 83,666,932,968.42 |
| **1.1.4** | Буцаан авсан албан татвар | 79,848,405.00 | 92,396,368.54 |
| **1.1.6** | Бусад мөнгөн орлого | 379,153,242.36 | 441,932,299.64 |
| **1.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **95,786,513,713.26** | **79,549,372,466.54** |
| **1.2.1** | Ажиллагчдад төлсөн | 15,575,489,034.67 | 20,937,485,156.83 |
| **1.2.2** | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 10,235,239,376.29 | 4,953,792,287.27 |
| **1.2.3** | Бараа материал худалданавахад төлсөн | 21,335,262,352.90 | 23,775,226,535.39 |
| **1.2.4** | Ашиглалтын зардалд төлсөн | 10,775,473,733.85 | 9,729,157,048.14 |
| **1.2.5** | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлдтөлсөн | 18,974,174,763.03 | 16,119,981,976.11 |
| **1.2.6** | Хүүгийн төлбөрт төлсөн | 2,464,032.74 | 1,271,996.91 |
| **1.2.7** | Татварын байгууллагад төлсөн | 14,141,321,517.38 | 3,280,542,380.60 |
| **1.2.9** | Бусад мөнгөн зарлага | 4,747,088,902.40 | 751,915,085.29 |
| **1.3** | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **3,226,516,816.45** | **4,651,889,170.06** |
| **2** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| **2.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **128,520,548.00** | **78,288,133.44** |
| **2.1.1** | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | | |
| **2.1.6** | Хүлээн авсан хүүгийн орлого | 128,520,548.00 | 78,288,133.44 |
| **2.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **-** | **10,540,476,594.30** |
| **2.2.1** | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | 8,005,688,821.72 |
| **2.2.5** | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | | 2,534,787,772.58 |
| **2.3** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **128,520,548.00** | **(10,462,188,460.86)** |
| **3** | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| **3.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **4,585,145,966.55** | **21,172,218.10** |
| **3.1.1** | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 4,573,342,690.55 | - |
| **3.1.4** | Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг | 11,803,276.00 | 21,172,218.10 |
| **3.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **2,529,246,766.30** | **12,202,995.48** |
| **3.2.1** | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 2,528,203,846.30 | - |
| **3.2.2** | Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | | |
| **3.2.5** | Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал | 1,042,920.00 | 12,202,995.48 |
| **3.3** | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **2,055,899,200.25** | **8,969,222.62** |
| **4** | Валютын ханшийн зөрүү | | |
| **5** | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **5,410,936,564.70** | **(5,801,330,068.18)** |
| **6** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 632,857,858.70 | 6,043,794,423.40 |
| **7** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 6,043,794,423.40 | 242,464,355.22 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*/төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмч | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| **2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **287,684,089,300.00** | **420,000,000.00** | **41,284,046,790.95** | **2,861,655,327.46** | **(142,722,666,690.88)** | **189,527,124,727.53** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | | - |
| **Залруулсан үлдэгдэл** | **287,684,089,300.00** | **420,000,000.00** | **41,284,046,790.95** | **2,861,655,327.46** | **(142,722,666,690.88)** | **189,527,124,727.53** |
| Өмчит гарсан өөрчлөлт | (275,738,820,300.00) | | | | (2,470,643,668.05) | (278,209,463,968.05) |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | | 12,246,763,462.31 | 12,246,763,462.31 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | - | - |
| Зарласан ногдол ашиг | | | | | | - |
| **2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **11,945,269,000.00** | **420,000,000.00** | **41,284,046,790.95** | **2,861,655,327.46** | **(132,946,546,896.62)** | **(76,435,575,778.21)** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | 168,005,060.07 | 168,005,060.07 |
| **Залруулсан үлдэгдэл** | **11,945,269,000.00** | **420,000,000.00** | **41,284,046,790.95** | **2,861,655,327.46** | **(132,778,541,836.55)** | **(76,267,570,718.14)** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | | 11,255,189,875.54 | 11,255,189,875.54 |
| Өмчит гарсан өөрчлөлт | | | | 2,567,116,147.20 | | 2,567,116,147.20 |
| Зарласан ногдол ашиг | | | | | (5,815,347,850.00) | (5,815,347,850.00) |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | - | | | - |
| **2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **11,945,269,000.00** | **420,000,000.00** | **41,284,046,790.95** | **5,428,771,474.66** | **(127,338,699,811.01)** | **(68,260,612,545.40)** |

### 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

| № | Үзүүлэлтүүд | Х/н | 2022 оны гүйцэтгэл | 2023 он | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **А** | **Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт** | | | | | | |
| 1 | Цемент | тн | 403,392.0 | 250,000.0 | 250,181.0 | 181.0 | 100.1 |
| | Шохой | тн | 51,672.0 | 50,000.0 | 44,860.0 | (5,140.0) | 89.7 |
| 2 | **НИЙТ ОРЛОГО** | **мян.төг** | **96,675,301.7** | **91,428,594.2** | **86,268,361.1** | **(5,160,233.1)** | **94.4** |
| | Үндсэн үйл ажиллагааны орлого | мян.төг | 95,854,747.8 | 90,287,807.7 | 85,605,128.1 | (4,682,679.6) | 94.8 |
| | Үйл ажиллагааны бус орлого | мян.төг | 820,553.9 | 600,786.4 | 663,233.0 | 62,446.6 | 110.4 |
| 3 | **НИЙТ ЗАРДАЛ** | **мян.төг** | **84,428,538.3** | **81,950,279.9** | **73,262,280.8** | **(8,687,999.1)** | **89.4** |
| | Үүнээс: Удирдлагын зардал | мян.төг | 3,218,948.0 | 4,663,317.2 | 9,563,645.6 | 4,900,328.4 | 205.1 |
| 4 | Татварын өмнөх ашиг/алдагдал/ | мян.төг | 12,246,763.5 | 9,478,314.3 | 13,006,080.3 | 3,527,766.0 | 137.2 |
| **5** | **Цэвэр ашиг/алдагдал/** | **мян.төг** | **12,246,763.5** | **8,008,735.7** | **11,255,189.9** | **3,246,454.2** | **140.5** |
| 6 | **Төсвийн төлбөр нийт дүн** | **мян.төг** | **24,376,560.9** | **9,851,666.8** | **8,234,334.8** | **(1,617,332.0)** | **83.6** |
| | а/ Орлогын татварт | мян.төг | 1,316,042.5 | 493,744.0 | 50,000.0 | (443,744.0) | 10.1 |
| | б/ НӨАТ | мян.төг | 6,889,327.7 | 3,786,530.2 | 1,372,760.6 | (2,413,769.6) | 36.3 |
| | в/ НДШ | мян.төг | 10,235,239.4 | 3,151,680.4 | 4,953,792.3 | 1,802,111.9 | 157.2 |
| | г/ Хүн амын орлогын татвар | мян.төг | 2,912,197.3 | 1,329,215.5 | 1,136,235.8 | (192,979.7) | 85.5 |
| | д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар | мян.төг | 2,126,493.1 | 570,473.9 | 520,741.0 | (49,732.9) | 91.3 |
| | е/ Гаалийн татвар | мян.төг | | | | | |
| | ё/ Тээврийн хэрэгслийн татвар | мян.төг | 1,519.1 | 6,220.0 | 5,205.1 | (1,014.9) | 83.7 |
| | ж/ Бусад | мян.төг | 581,360.4 | 513,802.8 | 195,600.0 | (318,202.8) | 38.1 |
| 7 | Төрийн өмчийн ногдол ашиг /өглөг/ | мян.төг | | 5,718,560.0 | | | |
| **8** | **Нийт ажиллагсдын тоо** | **хүн** | **730** | **765** | **765** | - | 100.0 |
| **9** | **Нийт цалингийн сан** | **мян.төг** | **19,746,742.4** | **26,777,810.4** | **25,654,486.2** | (1,123,324.2) | 95.8 |
| **10** | **Нэг ажилтны дундаж цалин** | **төг** | **2,254.2** | **2,916,973.0** | **2,794,606.0** | (122,367.0) | 95.8 |
| 11 | Борлуулалтын 1 төгрөг ногдох зардал | төг | 0.85 | 0.92 | 0.85 | (0.07) | 92.4 |
| **12** | **Хөрөнгө оруулалт** | **мян.төг** | **5,261,357.0** | **28,069,923.2** | **8,005,688.8** | **(20,064,234.4)** | **28.5** |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,732.9 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 1,732.9 сая төгрөгийн алдааг залруулуулсан.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Чулуунцарын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн их засварт хөрөнгийн өртөгт капиталжих зардлыг зардалд бүртгэсэн. | 1 | 988,512.4 | | | 1 | 988,512.4 | 1 | 988,512.4 | | | | |
| Компани үйлдвэрийн болон захиргааны барилгын дээврийн их засварын зардлыг үйлдвэрлэлийн болон удирдлага борлуулалтын зардалд бүртгэсэн байна. | 1 | 410,836.5 | | | 1 | 410,836.5 | 1 | 410,836.5 | | | | |
| Үйлдвэрлэл болон удирдлагын зардалд хуваарилагдах цайны газар, зочид буудлын зардлыг үйл ажиллагааны бус зардалд хуваарилсан | 1 | 325,922.8 | | | 1 | 325,922.8 | 1 | 325,922.8 | | | | |
| Хүүгийн орлогын албан татварын зардлыг үйл ажиллагааны бус зардалд бүртгэсэн, Тээвэр хөгжлийн банкны харилцах дансанд орж ирсэн хүүгийн орлогод татвар ногдуулж тайлагнаагүй | 1 | 7,678.0 | 1 | 6,406.0 | 1 | 1,272.0 | 1 | 7,678.0 | | | | |
| **Дүн** | **4** | **1,732,949.7** | **1** | **6,406.0** | **4** | **1,726,543.7** | **4** | **1,732,949.7** | | | | |

Аудитаар нийт 66,487.8 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 6.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 64,122.9 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 2,358.4 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | АТ-ны тоо | Тоо | Дүн |
| Ажилчдын цалингийн зардлын давтан тооцооллыг хийхэд илүү цагийн нэмэгдэл цалинг зөрүүтэй олгосон | 1 | 4,901.9 | 1 | 4,901.9 | | - | | - | | | | |
| Үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа уул уурхайн хүнд даацын HOWO 96-76 СЭҮ, Автогрейдер CR-180 машин механизм, СЭҮ 00-16 Toyota Land Criuser-200 үйлчилгээний автомашины шатахуун зарцуулалтыг давтан тооцоолоход батлагдсан нормоос илүү олгосон | 1 | 1,596.8 | 1 | 1,596.8 | | - | | - | | | | |
| Мөнгөн хөрөнгийн орлого зарлагын гүйлгээнээс анхан шатны баримтруу тулган шалгахад ажил үйлчилгээний худалдан авалт нь төлбөрийн и-баримтаар баталгаажаагүй | 1 | 3,068,465.2 | | | 1 | 3,068,465.2 | | | | | | |
| Санхүүгийн тайланд толилуусан авлагын дүнгээс шүүхэд шилжүүлсэн, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй | 1 | 45,723,618.2 | | | 1 | 45,723,618.2 | | | | | | |
| Санхүүгийн тайланд толилуулсан өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй | 1 | 12,867,857.9 | | | 1 | 12,867,857.9 | | | | | | |
| Нэмэгдсэн хасагдсан хөдөлгөөн ороогүй бараа материалаас өмнөх онруу хөөн шалгахад 2 жил дараалан зарцуулаагүй бараа материал байна. | 1 | 1,573,139.3 | | | 1 | 1,573,139.3 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Их хэмжээний эхний үлдэгдэлтэй барааг нэмж худалдан авч үлдэгдлийг нэмэгдүүлсэн эсвэл эхний үлдэгдлийн тоо хэмжээнээс бага зарцуулж байгаа боловч нэмж худалдан авалт хийсэн | 1 | 757,451.9 | | | 1 | 757,451.9 | | | | | | |
| Дараа тооцооны гүйцэтгэлээр хугацаа хэтэрсэн томилолт, дараа тооцооны авлага бүртгэлтэй, дараа тайлангаар мөнгө зарлагадах үндэслэл, тооцоог хаах хугацаа, бүрдүүлэх баримт, тайлагналын талаар тодорхойлсон журамгүй | 1 | 15,548.5 | | | 1 | 15,548.5 | | | | | | |
| Компани үүсгэн байгуулагдсаны 40 жилийн ойн арга хэмжээнд хөрөнгө зарцуулсан | 1 | 116,845.0 | | | 1 | 116,845.0 | | | | | | |
| Санхүүгийн тайлан дахь татварын өглөг нь татварын тайлангаарх өглөгийн дүнгээс зөрүүтэй буюу илүү тайлагнасан | 1 | 942,257.1 | | | | | 1 | 942,257.1 | | | | |
| Агуулахад олон жил болсон ашиглагдахгүй болон актлах бараа материал бүртгэлтэй байна. | 1 | 1,054,375.0 | | | | | 1 | 1,054,375.0 | | | | |
| Засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох вагоны дугуйн үнийг төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоолгүйгээр актлаж шууд зардалд бүртгэсэн | 1 | 280,000.0 | | | | | 1 | 280,000.0 | | | | |
| Тайлант онд худалдан авалт хийсэн боловч зарцуулаагүй барааны хяналтын тооллогоор 59.3 сая төгрөгийн барааг тоолох боломжгүй байна. | 1 | 59,309.3 | | | | | 1 | 59,309.3 | | | | |
| Харилцах, кассаар олгосон шагнал урамшуулал, тэтгэмжийн орлогоос хувь хүний орлогын албан татвар ногдуулж суутгасан боловч тайлагнаагүй | 1 | 22,346.0 | | | | | 1 | 22,346.0 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бараа материалын дэлгэрэнгүй тайлангийн үлдэгдэл санхүүгийн тайлангийн үлдэгдлээс зөрүүтэй буюу дутуу тайлагнасан | 1 | 78.4 | | | | | 1 | 78.4 | | | | |
| Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа "Даймонд 5" санхүүгийн програмаас гарч байгаа ерөнхий журнал болон зарим анхан шатны баримт нь холбогдох хууль тогтоомжид нийцэхгүй | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Жилийн эцсийн үндсэн хөрөнгийг тооллогыг 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрөөр тасалбар болгосон нь жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дүнгээс зөрүүтэй | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Компани холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тэтгэвэрт гарсан ажилчдад олгох тэтгэмжид зориулан тусгай сан байгуулаагүйгээс тэтгэвэрт гарсан ажилтны тэтгэмжийг үйл ажиллагааны бус зардлаар бүртгэсэн | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| **Дүн** | **18** | **66,487,790.5** | **2** | **6,498.7** | **7** | **64,122,926.0** | **9** | **2,358,365.8** | | | | |

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 186,730.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс 186,730.9 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсанд 186,730.9 сая төгрөгийн цалингийн зардлаас бусад таван саяас дээш үнийн дүнтэй зарлагын мэдээлэл ба хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн 133 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 1 | 186,730,979.8 | 1 | 186,730,979.8 | | |
| **Дүн** | **1** | **186,730,979.8** | **1** | **186,730,979.8** | | |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | |
| Үйл ажиллагаандаа ашиглаж байгаа 85 тээврийн хэрэгслийн улсын дугаарын өнгийг холбогдох хууль тогтоомжийн заалттай нийцүүлэн өөрчлөөгүй байна. | 1 | | | | 1 | |
| ТУЗ-ийн дэргэдэх аудитор болон дотоод хяналтын хэлтэс нь компанийн үйл ажиллагааг сайжруулах үр дүнтэй зөвлөмжийг хүргүүлэн гүйцэтгэлийг цаг хугацаанд нь хянаж ажиллаагүй байна. | 1 | | 1 | | | |
| Дахин тодотгосон төлөвлөгөөнд тусгасан зорилтот түвшний үзүүлэлтүүд хангалттай биелэгдээгүй, борлуулалт өмнөх оноос 40 хувиар буурсан, төрийн өмчийн 2022 оны ногдол ашиг төлөгдөөгүй байхад цалингийн сан өмнөх онтой харьцуулахад 5,907.8 сая төгрөгөөр өссөн байна. | 1 | | | | 1 | |
| Цемент шохой ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 08 дугаар сарын 31-ний 04 дүгээр тогтоолоор баталсан дүрэмд “Цемент шохой” ХХК-ийн өмч нь нэг бүр 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 119,452,690 ширхэг 11,945.3 сая төгрөгийн энгийн хувьцаанаас бүрдэнэ гэж заасан байгаа боловч улсын бүртгэлийн гэрчилгээнд нийт өмчийг 287,684.1 сая төгрөгөөр бүртгэсэн байна. | 1 | | 1 | | | |
| **Дүн** | **4** | | **2** | | **2** | |
| **Нийт дүн** | **5** | **186,730,979.8** | **3** | **186,730,979.8** | **2** | |